

ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД БОЛОН АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА НАРТАЙ БАЙГУУЛСАН ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАНИЛЦУУЛГА

Нэг. Зорилго

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь Эдийн засаг, хөгжлийн сайдын Засаг дарга нартай байгуулсан гэрээний үүргийн биелэлт болон үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулж байгаа болон шийдвэр гаргах түвшинд мэдээлэл, арга зүйн дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэнэ.

Хоёр. Арга зүй

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралт “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.2 “бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэх” аргачлалаар хяналт-шинжилгээ, үнэлгээг хийлээ.

Гэрээнд тусгагдаагүй заалтын биелэлт ирүүлсэн бол үнэлгээнд оруулж тооцоогүй бөгөөд гэрээнд тусгасан боловч биелэлт ирүүлээгүй арга хэмжээг “0 хувь буюу хэрэгжээгүй” гэж үнэлсэн.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Гэрээний зорилго нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээний чанар, үр ашгийг дээшлүүлэхэд хамтран ажиллах, үйл ажиллагаагаа уялдуулан зохицуулахад оршиж байгаа бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 02-ны өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл 1 жилийн хугацаатай байгуулсан.

Гэрээний хоёрдугаар хавсралтад Засаг даргын гүйцэтгэх арга хэмжээг 3 зорилтын хүрээнд тусгасан бөгөөд аймаг тус бүрийн онцлогоос хамааран нэмэлт арга хэмжээг тусгасан байна.

3.1. “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнах ажлын хүрээнд” зорилтын хэрэгжилт

Тус зорилтын хүрээнд нийтлэг 5 арга хэмжээг хэрэгжүүлэхээр аймгуудын гэрээнд тусгасан ба Баян-Өлгий, Дорноговь, Сэлэнгэ аймгуудад “Цагааннуур, Замын-Үүд, Алтанбулаг чөлөөт бүсүүдийг хөгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах”, Өмнөговь, Баян-Өлгий, Завхан, Хөвсгөл, Сүхбаатар, Дорноговь, Булган, Сэлэнгэ, Төв, Увс, Говь-Алтай, Ховд, Дорнод аймгуудад “хилийн боомтыг хөгжүүлэхэд орон нутгийн зүгээс дэмжлэг үзүүлэх” гэсэн заалтуудыг нэмж тусгасан байна.

Төв аймгийн гэрээнд боомтыг хөгжүүлэх чиглэлийн заалтыг оруулж, Баянхонгор аймагт тус заалтыг хасаж гэрээг баталсан тул гэрээний биелэлтийг тооцохдоо тус 2 аймгийн заалтыг сольж тооцсон болно./

Гэрээний 1.1 “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлд хамтран ажиллах арга хэмжээний хэрэгжилт 77.7 хувийн үнэлгээтэй гарсан бөгөөд нийслэл болон 4 аймаг 30.0 хувийн үнэлгээтэй байна.

Гэрээний нэмэлт заалт /1/ Хилийн боомтыг хөгжүүлэхэд орон нутгийн зүгээс дэмжлэг үзүүлэх арга хэмжээний биелэлтийг гэрээнд тусгасны дагуу 13 аймгаас ирүүлсэн ба хэрэгжилт дунджаар 75.4 хувийн үнэлгээтэй.

Гэрээний нэмэлт заалт /2/ Чөлөөт бүсийг хамтран хөгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах арга хэмжээний биелэлтийг 3 аймгаас ирүүлсэн бөгөөд хэрэгжилт 0 үнэлгээтэй, тайланг арга хэмжээний хүрээнд болон шалгуур үзүүлэлтийн хүрээнд тайлагнахгүй байна.

Гэрээний 1.2 Орон нутагт хөрөнгө оруулалт татах, сурталчлах, мэдээлэл харилцан солилцох арга хэмжээний биелэлт 75.0 хувийн үнэлгээтэй.

Гэрээний 1.3 “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”, “Бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөр”-ийн төсөлд тусгах саналаа аймгийн ИТХ-аар хэлэлцүүлж, батлагдсан хувилбарыг хүргүүлэх арга хэмжээний биелэлт 67.7 хувийн үнэлгээтэй гарсан ба тайланг шалгуур үзүүлэлтийн хүрээнд тайлагнаагүй, өмнөх оны тайлан бичсэн зэрэг асуудлууд гарч байна.

Гэрээний 1.4 Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.9-д заасан “Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө”-ний төслийг тус хуулийн 18.5-д заасан хугацаанд холбогдох хууль, журамд заасан шаардлагуудыг ханган боловсруулж, Эдийн засаг, хөгжлийн яамны саналыг авч, мөн хуулийн 18.6-д заасан хугацаанд батлуулах арга хэмжээ 100.0 хувийн биелэлттэй.

Гэрээний 1.5 Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайланг холбогдох журамд заасан хугацаанд ИТХ-аар хэлэлцүүлэн баталгаажуулж, танилцуулгын хамт хүргүүлэх арга хэмжээний биелэлт 95.5 хувийн биелэлттэй байна.

Гэрээний үндсэн зорилт болох хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнах хүрээнд дундаж үнэлгээ 70.2 хувийн биелэлттэй, тодорхой үр дүн гарч эхэлж байгаа, цаашид үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

3.2. “Эдийн засаг, хөгжлийн яамнаас эрхлэн хөтөлж байгаа цахим мэдээллийн санг хөгжүүлэх” зорилтын хэрэгжилт

Тус зорилтын хүрээнд 2 арга хэмжээг гэрээнд тусгасан бөгөөд 21 аймаг, нийслэлээс тайланг ирүүлсэн. Үүнд:

Гэрээний 2.1 Эдийн засаг, хөгжлийн яамны цахим мэдээллийн системүүдийг орон нутгийн холбогдох мэдээллээр тогтмол хангаж ажиллах арга хэмжээний хэрэгжилт дунджаар 70.0 хувийн үнэлгээтэй гарсан. Тус арга хэмжээний хэрэгжилтийг тооцоход 4 аймаг 0 үнэлгээтэй гарсан бөгөөд арга хэмжээний хүрээнд хамааралгүй ажил бичсэн, үнэлгээг өндөр тавьсан, тайлан ирүүлээгүй байна.

Гэрээний 2.2 Орон нутгийн хөгжлийн индекс тооцох цахим системд сумдын хөгжлийн индексийн мэдээллийг 2021 оны байдлаар шинэчилж оруулах; www.lidi.nda.gov.mn арга хэмжээний хэрэгжилт дунджаар 90.9 хувийн биелэлттэй гарсан бөгөөд нийслэл болон Дорнод аймаг 0 хувиар үнэлэгдсэн. Нийслэлийн хувьд тус арга хэмжээг нийслэлд хамааралгүй, хасах саналаар ирүүлсэн, Дорнод аймгийн хувьд 2020 оны тайланг бичсэн, тайланг дутуу тайлагнасан байна.

Эдийн засаг, хөгжлийн яамнаас эрхлэн хөтөлж байгаа цахим мэдээллийн санг хөгжүүлэх зорилтын хүрээнд биелэлт дунджаар 80.5 хувийн үнэлгээтэй, тодорхой үр дүнд хүрсэн байна.

3.3. “Орон нутгийн хөгжлийн бодлого төлөвлөгч нарыг чадавхжуулах” зорилтын хэрэгжилт

Тус зорилтын хүрээнд 2 арга хэмжээг хамтран хэрэгжүүлэхээр гэрээнд тусгасан бөгөөд хэрэгжилт дунджаар 72.3 хувийн биелэлттэй байна.

Гэрээний 3.1 Орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах сургалтад хөгжлийн бодлого төлөвлөгч нарыг хамруулах арга хэмжээний биелэлтийг 21 аймгаас ирүүлсэн ба биелэлт дунджаар 72.9 хувьтай байна. Шалгуур үзүүлэлтийг “зохион байгуулсан сургалтын тоо” гэж тогтоосон ч хамааралгүй тайлан бичсэн, Засгийн газраас болон бусад байгууллагаас зохион байгуулсан сургалтад хамрагдсан зэрэг тайланг ирүүлсэн бөгөөд 8 аймаг сургалт зохион байгуулсан, хэрэгжилт үр дүнтэй үнэлэгдсэн.

Гэрээний 3.2 Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын чиглэлийн хурал, зөвлөгөөн, хэлэлцүүлгийг хамтран зохион байгуулах, оролцоог хангах арга хэмжээний хэрэгжилт 71.8 хувийн биелэлттэй үнэлэгдсэн. Ковидын болон Төрийн хэмнэлтийн хуультай холбоотойгоор сургалт зохион байгуулаагүй 2 аймаг 0 үнэлгээтэй үнэлэгдсэн бөгөөд дийлэнх аймгууд “Эдийн засгийн форум”-д оролцсон гэсэн тайланг ирүүлсэн байна.

Дөрөв. Дүгнэлт

Эдийн засаг, хөгжлийн сайдаас Засаг дарга нартай хамтран ажиллах гэрээний хэрэгжилтэд гэрээний гуравдугаар хавсралт “хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин”-ий дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд хэрэгжилт дунджаар 79.1 хувийн биелэлттэй, журмын 6.2.3 заалтын дагуу “зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүн гарч эхэлж байгаа, цаашид үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай” гэж дүгнэж байна.

Аймаг тус бүрээр хэрэгжилтийг тооцоход, үр дүнтэй буюу 100.0 хувийн хэрэгжилттэй аймаг байхгүй, 17 аймаг, нийслэл 70-100 хүртэл хувийн үнэлгээтэй, тодорхой үр дүнд хүрсэн бол 4 аймаг эрчимжүүлэх шаардлагатай буюу 70-50 хүртэл хувийн үнэлгээтэй гарч байна.

Биелэлт хангалтгүй үнэлэгдсэн арга хэмжээний хувьд гэрээнд заасны дагуу Эдийн засаг, хөгжлийн яамтай хамтран хэрэгжүүлсэн арга хэмжээ, шалгуур үзүүлэлтийн хүрээнд тайлагнаагүй, тайлан дутуу, хэт товчилсон, тодорхойгүй байдлаар биелэлтийг ирүүлж байна.

Эдийн засаг, хөгжлийн сайдаас Засаг дарга нартай байгуулсан хамтран ажиллах гэрээний хэрэгжилт, аймаг бүрээр

Зорилт		Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнах							ЭЗХЯ-аас эрхлэн хөтөлж байгаа цахим мэдээллийн санг хөгжүүлэх		Орон нутгийн хөгжлийн бодлого төлөвлөгч нарыг чадавхжуулах		ЭЗХЯ нийт үнэлгээ хувиар
		1.1	н1	1.2	1.3	н2	1.4	1.5	2.1	2.2	3.1	3.2	
1	Архангай	30	-	50	50	-	100	100	100	100	100	70	77.8
2	Баян-Өлгий	30	50	30	70	0	100	100	70	100	50	50	59.1
3	Баянхонгор	100	50	90	100	-	100	100	100	100	50	70	86.0
4	Булган	100	100	100	70	-	100	100	30	100	70	100	87.0
5	Говь-Алтай	100	70	100	50	-	100	100	100	100	70	70	86.0
6	Дорноговь	100	100	30	0	0	100	100	90	100	100	50	70.0
7	Дорнод	90	70	100	50	-	100	100	100	0	30	70	71.0
8	Дундговь	100	-	50	100	-	100	100	100	100	70	70	87.8
9	Завхан	30	70	50	0	-	100	100	70	100	50	50	62.0
10	Өвөрхангай	100	-	100	100	-	100	100	100	100	100	0	88.9
11	Өмнөговь	100	100	70	90	-	100	100	70	100	100	90	92.0
12	Сүхбаатар	100	30	100	70	-	100	100	0	100	100	0	70.0
13	Сэлэнгэ	30	50	50	50	0	100	100	100	100	70	100	68.2
14	Төв	100	-	100	70	-	100	100	100	100	100	100	96.7
15	Увс	100	100	70	90	-	100	100	50	100	70	70	85.0
16	Ховд	30	100	50	70	-	100	100	90	100	70	70	78.0
17	Хөвсгөл	70	90	90	100	-	100	100	100	100	50	100	90.0
18	Хэнтий	100	-	50	50	-	100	100	0	100	100	50	72.2
19	Дархан-Уул	100	-	70	90	-	100	100	100	100	50	100	90.0
20	Нийслэл	30	-	100	100	-	100	100	-	0	-	100	75.7
21	Орхон	100	-	100	70	-	100	100	0	100	100	100	85.6
22	Говь-сүмбэр	70	-	100	50	-	100	0	0	100	30	100	61.1
ДҮН		77.7	75.4	75.0	67.7	0.0	100.0	95.5	70.0	90.9	72.9	71.8	79.1
		70.2 хувь							80.5 хувь		72.3 хувь		

Тав. Цаашид авах арга хэмжээний санал

- Гэрээний хугацаа дуусаж, хэрэгжилтийн тайланг өгөхдөө “тухайн арга хэмжээ хамааралгүй, хасах саналтай” гэж ирүүлж байгаа тул гэрээнд тусгах арга хэмжээг гэрээг батлахаас өмнө харилцан хянаж, баталгаажуулах;
- Эдийн засаг, хөгжлийн яамны цахим мэдээллийн системүүдийг орон нутгийн холбогдох мэдээллээр тогтмол хангаж ажиллах арга хэмжээний биелэлтийн тайланд нийслэл, Сүхбаатар аймгаас [“http://industry.gov.mn/](http://industry.gov.mn/) болон <http://sector.gov.mn/> цахим мэдээллийн сангууд засвартай ажиллаагүй байна” гэсэн тайлбарыг ирүүлсэн байгаа тул хариуцсан нэгжээс орон нутгийг мэдээллээр байнга хангах, хамтран ажиллах;
- Гэрээний биелэлтийг ирүүлэхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 3.1.4-д заасан “тайлан дүгнэлт нь тухайн бодлого, үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг тодорхойлсон, нотлогдохуйц байх” гэсэн зарчмыг баримтлан баримт материалыг хавсаргаж байх, тайланг шалгуур үзүүлэлтийн дагуу тодорхой, иж бүрэн өгөхөд анхаарч ажиллах;
- Гэрээний 1.5 “Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайланг холбогдох журамд заасан хугацаанд ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулж, танилцуулгын хамт хүргүүлэх” арга хэмжээний хувьд хэрэгжилтийн тайланг дараа оны 3 дугаар сарын 1-ний дотор Эдийн засаг, хөгжлийн яаманд ирүүлэхээр журамласан тул гэрээнд тусгахдаа хяналт-шинжилгээ, үнэлгээний журамтай уялдуулах;
- Гэрээний 2.3-д заасны дагуу гэрээний нөхцөлийг хэрхэн биелүүлж байгаад харилцан хяналт тавьж, хамтран ажиллах шаардлагатай.

Нийслэлээс ирүүлсэн санал:

- Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчтай 2022 онд хамтран ажиллах гэрээний хоёрдугаар хавсралтын 1.3 дахь хэсэгт заасан "Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал", "Бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөр"-ийн төсөлд тусгах саналаа нийслэлийн ИТХ-аар хэлэлцүүлж, батлагдсан хувилбарыг хүргүүлэх гэсэн заалтыг хасаж, 2023 онд хамтран ажиллах гэрээнд тусгах;
- Мөн гэрээний хоёрдугаар хавсралтын 2.1 дэх хэсэгт заасан Эдийн засаг, хөгжлийн яамны цахим мэдээллийн системүүдийг орон нутгийн холбогдох мэдээллээр тогтмол хангаж ажиллах гэсэн заалтад өөрчлөлт оруулах эсвэл хасах, нийслэлээс мэдээллээр хангах цахим санг тодорхой болгон тусгах.

ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР